

ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № 75

2022 оны 5 сарын 25 өдөр

Байгууллагын нэр: Байгаль орчны газар	Дансны дугаар	38,078,801.00
Регистрийн дугаар: 9006974	100020013001	
Хүдлэгт авагчийн нэр: БАЛГЫН ХХК	Дансны дугаар	
Регистрийн дугаар: 2142864	5805011518	
Хүлээн авагчийн банк: Голомт банк	Ангилал	
Мөнгөн дун үсгээр: Гучин найман сая далан найман мянга найман зуун нэгэн төгрөг 00 мөнгө		
Гүйлгээний утга:	71406 - Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	38,078,801.00
Тарьц, суулгацны үнэ	81701 - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	
	0000 - Төрийн сан	
	210801-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	

Хяналтын хуудас №: 75

Үндэслэх бичиг баримтын нэр		Он сар, дугаар	Төрийн сангийн тэмдэглэгээ
1	Гэрээ	2022.05.24 №БОХ-06/2022	✓
2	Тушаал	2022.05.24 №А/16	✓

Тамга

Дарга:  /Ш.Марат/

Нягтлан бодогч:  /Х. Тилеухан/



ӨЛГИЙ 2022 ОН

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ, ОРЧИН АЯЛАЛ,
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.МАРАТ ТАНАА

2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр

№08

Өлгий хот

Дүгнэлт хүргүүлэх тухай

Тарьц, суулгац нийлүүлэх ажил нийлүүлэх БӨАОНӨГ/202205091 дугаартай ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны дүгнэлтийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.2.2-д заалтын дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Үнэлгээний хорооны дүгнэлтээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 заалтын дагуу Балгын ХХК-тай 68,684,001.0 /жаран найман сая зурган зуун наян дөрвөн мянган нэг/ төгрөгийн гэрээ байгуулахыг санал болгож байна.

Үнэлгээний хорооны дүгнэлт, холбогдох материалыг хавсаргав.

Танилцсан: Үнэлгээний хорооны дарга:



Б.Ботакөз

Гишүүд:



Ц.Кенжегүл

Нарийн бичгийн дарга:



Х.Жанибек

2022 оны 05-р сарын 19-ний өдөр

1. Балгын ХХК-д

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт болон 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг үндэслэн Тарьц, суулгац нийлүүлэх ажил нийлүүлэх ажлын БӨАОНӨГ/202205091 дугаартай ажлыг 68,684,001.0 /жаран найман сая зурган зуун наян дөрвөн мянган нэг/ төгрөгөөр 2022 оны 05 дугаар сарын 17-ний өдөр ирүүлсэн тендер шалгарсан болохыг мэдэгдье.

Мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Танилцсан: Үнэлгээний хорооны дарга:

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:



Б.Ботакөз

Ц.Кенжегүл

Х.Жанибек

2022 оны 05-р сарын 19-ний өдөр

ТАНИЛЦУУЛГА

2022 оны аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Тарьц, суулгац нийлүүлэх ажил нийлүүлэх ажлын БӨАОНӨГ/202205091 дугаартай бараа

Санхүүжилт: 70 000 000 /арван таван сая/ төгрөг.

Тендерийн бичиг баримт боловсруулах, тендер зарлах.

Аймгийн Засаг даргын 2022 оны 05-р сарын 10-ны өдрийн А/27 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Харьцуулалтын аргаар ажил худалдан авах жижиг баримт бичгийг ашиглан тендерийн бичиг баримтыг боловсруулан захиалагчаар батлуулан 2022 оны 05-р сарын 10-нд tender.gov.mn веб сайтад хялбаршуулсан цахимаар нийтэлсэн.

Тендерийн хүчинтэй хугацаа ба хаах өдөр.

Тендерийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд хүчинтэй. Тендерийн бичиг баримт хүлээж авсан эцсийн хугацаа 2022 оны 05-р сарын 17-нд 10 цаг 00 минут болно.

Тендерийн баримт бичгийг ирүүлэх нээх өдөр.

Урилгад заасны дагуу Тендерийг 2022 оны 05-р сарын 17-нд 10 цаг 00 минут хүртэл хүлээн авч 2022 оны 05-р сарын 17-нд 10 цаг 30 минутад оролцогчийг байлцуулан тендерийг нээсэн. Үүнд 1 компани тендерт оролцох хүсэлт гаргаж тендерийн бичиг баримт ирүүлсэн.

Компаниудын ирүүлсэн үнийн санал.

№	Компани	Үнийн санал	Үнийн хөнгөлөлт	Үнийн хөнгөлөлт хассан дүн
1	Балгын ХХК	70,000,000.0	1,315,999.0	68,684,001.0
2				

Тендер үнэлгээний журам:

Тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу, мөн сангийн сайдын 2012 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Тендерийн үнэлгээний заавар”-ын дагуу үнэлсэн. Нээлтийн болон үнэлгээний тэмдэглэлийг хавсаргав.

Тендерийг дараах байдлаар хянан үзэв:

- Эрх бүхий эсэх
- Тендерийн баталгаа гаргасан эсэх.
- Гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэх.
- Магадлах
- Баримт бичиг бүрэн гүйцэд эсэх.

Үнэлгээний хорооны зөвлөмж:

Үнэлгээний хорооны дүгнэлтээр, захиалагчийн тендерийн бичиг баримтад тусгасан шаардлагыг хангасан Балгын ХХК –ны ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзсэн.

Үнэлгээний хорооны дүгнэлт:

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт болон 46 дугаар зүйлийн 46.1.3-т заасныг үндэслэн Тарьц, суулгац нийлүүлэх ажил нийлүүлэх ажлын БӨАОНӨГ/202205091 дугаартай 68,684,001.0 /жаран найман сая зурган зуун наян дөрвөн мянган нэг/ төгрөгөөр гэрээ байгуулахыг санал болгож байна.



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/47

Өлгий

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тарьц, суулгац нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.


Үнэлгээний хорооны дарга: Б.Ботакөз Орон нутгийн өмчийн газрын ашиглалт, хяналт хариуцсан мэргэжилтэн

Гишүүн: Ц.Кенжегүл Орон нутгийн өмчийн газрын хууль эрх зүй, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга: Х.Жанибек Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн

2. Тендерийн бичиг баримтыг бэлтгэж, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг гаргуулж ажиллахыг үнэлгээний хороо / Б.Ботакөз/- д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.НАЗЫМ

ТАРЫЦ, СУУЛГАЦ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ БОЛОВСРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурал: 01 Анхны хурал 2022 оны 05-р сарын 10-ны өдрийн 15:00 цагт Аймгийн ОНӨГ-ын шилэн ерөөнд болов. Үнэлгээний хорооны бүх гишүүд ирсэн байна.

Хэлэлцэх асуудал: Тарьц, суулгац нийлүүлэх ажлын тендерийн бичиг баримт боловсруулах.

Хэлэлцсэн нь:

Б.Ботакөз: Энэхүү үнэлгээний хороог 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ОНӨГ-ын даргын тушаалаар Үнэлгээний хорооны даргаар аймгийн ОНӨГ-ын мэргэжилтэн Б.Ботакөз, гишүүдээр ОНӨГ-ын мэргэжилтэн ажилтан Ц.Кенженгүл, нарийн бичгийн даргаар ОНӨГ-ыг ахлах мэргэжилтэн Х.Жанибек нарын бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна.

Хамгийн түрүүнд Үнэлгээний хороонд гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил тухай мэдэгдлийг бөглөж тендер баримт бичиг боловсруулах ажилдаа оров.

Х.Жанибек: Тус ажлыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 04 сарын 15-ны өдрийн 120 дугаар албан тоотоор тендер зарлаж өгөхөөр техникийн тодорхойлолтыг ирүүлсэн байгаа. Төсөв өртөг нь 70.0 /далан/ сая төгрөг юм байна. Тус ажил харьцуулалтын аргаар зарлагдана.

1.Сүүлийн 2 жилийн /2019, 2020/ ижил төстэй ажлын жагсаалт, гэрээний хуулбар, улсын комиссын акт

2.Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.

3. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтуудыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.

/Тендерт оролцогчийн бичгээр ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./

4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна.

6. Харилцагч банкны тодорхойлолт гэсэн тендерийн баримт бичгийг төслийг товчхон танилцуулья

Б.Ботакөз: Х.Жанибекийн саналтай нэг байна, мод тарих хугацаа оройтож байгаа учраас хурдан шуурхай зарлах саналтай байна.

Ц.Кенжегүл. Та бүхний саналтай нэг байна.

Шийдвэрлэсэн нь:

Тус хурлаар Тарьц, суулгац нийлүүлэх ажилд 1.Сүүлийн 2 жилийн /2019, 2020/ ижил төстэй ажлын жагсаалт, гэрээний хуулбар, улсын комиссын акт

2.Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.

3. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолуудыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.

/Тендерт оролцогчийн бичгээр ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./

4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна.

6. Харилцагч банкны тодорхойлолт гэсэн гэсэн шалгууруудыг оруулах нэгдсэн нэг саналд хүрэв.

Үнэлгээний хорооны гишүүд НБД Х.Жанибек-д тус тендерийг 2022 оны 07 дугаар сарын 28-ний өдөр зарлахыг үүрэг болгов.

Тендер хүлээн авах эцсийн хугацаа 2022 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 10:00 цагаас тогтоов.


Тендер нээлтийн хугацаа 2022 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 10:30 цагаас тогтоов.

Танилцсан: Үнэлгээний хорооны дарга:



Б.Ботакөз

Гишүүд:



Ц.Кенжегүл

Нарийн бичгийн дарга:



Х.Жанибек

2022 оны 05 дугаар сарын 10-ний өдөр

ТАРЫЦ, СУУЛГАЦ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ТЕНДЕРИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурал: 03 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 14:00 цагт аймгийн ОНӨГ-ын шилэн өрөөнд болов. Үнэлгэний хорооны гишүүд бүгд ирэв.

Хэлэлцэх асуудал: Тарьц, суулгац нийлүүлэх ажлын сонгон шалгаруулах.

Б.Ботакөз. Нэг компани материал ирүүлсэн байгаа тул шалгаж шаардлага нийцсэн эсэхийг шалгаруулъя.

Үнэлгээний хорооны тавьсан шаардлагын дагуу үнэлгээ хийж, бүх ТББ баримттай нэг бүрчлэн танилцаж маягтын дагуу хянаж үзэв.

Х.Жанибек. Материал илгээсэн Балгын ХХК-ны хувьд урьд өмнө хийж байсан ижил төстэй ажлын туршлагатай, тус компанийн ажилтан Х.Мырзабек Баян-Өлгий аймгийн ШУА-ийн ЭШ-ий ажилтан ХААУхааны доктор (Ph.D) 2012 онд ХААИС-ийн агроэкологийн сургуулиас E20121190 дугаартай магистрын "Ховд голын сав газрыг ойжуулах суулгац материал ургуулах арга" сэдвээр ойн инженер, 2020 онд тус сургуулиас "Баян-Өлгий аймгийн байгалийн чацарганыг тархалт нөөц, нутгийн хэлбэрүүдийг судалсан дүн" сэдвээр Хөдөө аж ахуйн ухааны Докторын (Ph.D) зэргийг P2020Ю69 дугаартай төгссөн ба 2010 оноос "Балгын" ХХК-ны мэргэжлийн зөвлөхөөр, ойн инженер Өкей Елемес нь 2014 оноос ажиллаж байгаа туршлагатай ажилтнуудтай компани байна.

Б.Ботакөз: Туршлагатай мэргэжлийн ажилтнуудтай компани учраас дэмжиж байна.

Ц.Кенжегүл: Би мөн адилхан саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Техникийн болон захиалагчийн тавьж өгсөн үндсэн шаардлагыг хангаж, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тул үнэлгээний хорооны олонхын саналаар "Балгын" ХХК-ийг Тарьц, суулгац нийлүүлэх ажлыг 68,684,001.0 /жаран найман сая зурган зуун наян дөрвөн мянган нэг/ төгрөгөөр гүйцэтгэх эрх олгох дүгнэлт хүргүүлэхээр болов.

Хурал: 2022 оны 05 дугаар сарын 19 -ний өдрийн 14:50 минутад дуусав.

Танилцсан: Үнэлгээний хорооны дарга:

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:



Б.Ботакөз

Ц.Кенжегүл

Х.Жанибек

2022 оны 05-р сарын 19-ний өдөр

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
 ГАЗРЫН ДАРГА Ш. МАРАТ


ТАРЬЦ, СУУЛГАЦ ХУДАЛДАН АВАХ

Шалгуур	
Тарьц, суулгац нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд	“Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх” чиглэлийн мэргэжлийн байгууллагын эрхтэй байх.
	Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны тайланг гэрэл зургаар баталгаажуулах.
	Мод үржүүлгийн ажил хийх мэргэжлийн боловсон хүчинтэй байх. Мэргэжлийн боловсон хүчний диплом, мэргэжлийн үнэмлэх, ажилд орсон тушаал, хөдөлмөрийн гэрээ. /тэдгээрийг баталгаажуулах/ Удирдах болон инженер техникийн ажилтнуудын мэдээлэл, мэдэгдэл.
	Суулгацын MNS 6255:2011 стандартын шаардлага хангасан байх.
	Сүүлийн 5 жилд хийсэн ойжуулалт болон адил төстэй ажлын үр дүн, БОАЖГазартай гэрээгээр ажил хийж байсан бол давуу тал болно. /акт, гэрээний хувь, тайланг хавсаргах/
	Мод үржүүлгийн ажилд шаардлагатай ажлын багаж, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл түүнийг гэрэл зургаар баталгаажуулах. Автомашин түрээслэх гэрээ, үнэмлэх, баримт бичиг. Багаж тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт.
	Тарьц, суулгацын амьдралтыг дээшлүүлэх арга технологи, төлөвлөлтийн талаар захирлын болон ерөнхий инженерээр баталгаажуулсан технологийн карттай байх.
Бэлтгэл ажил	Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, ажлын төсөв. /баталгаажуулах/
	Ойжуулах, мод тарих талаар орон нутгийн иргэдэд зориулсан сургалт сурталчилгааг өргөнөөр хийх, иргэдийг татан оролцуулах.
Үндсэн ажил	Суулгацыг ачих буулгах, түр хадгалах технологи, горим.
	15.0 мянган ширхэг 3-аас дээш насны тарьц, суулгац нийлүүлэх.
	Тарьц, суулгац нь стандартын шардлага хангасан байх.
	Баталгаажуулсан технологийн дагуу тээвэрлэх, хадгалах талаар захирлын болон ерөнхий инженерээр баталгаажуулсан технологийн төлөвлөгөөтэй байх.

Тайлан боловсруулалтын ажил	Тарьц, суулгац нийлүүлсэн ажлын тайланг захиалагчид 2% ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсэгтэй байна. 1. Ажлын бичмэл тайлан. 2. Ажлын үе шатны гэрэл зургууд. 3. Санхүүгийн тайлан		
Нийлүүлэх суулгац	№	Тарьц, суулгацын нэр төрөл	Хэмжээ /мян.шир/
	1	Бургас	5.0
	2	Улиас	3.0
	3	Хайлаас	2.5
	4	Шар хуайс	1.5
	5	Шилмүүст мод	1.0
	6	Гоёлын мод	1.0
	7	Жимс жимсгэний мод	1.0
Дүн			15.0
Суулгацын стандарт /суулгацын өндөр нь хамгийн багдаа 0,6 см – ээс дээш/	Гадна талын байдал, өнгө хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин, хөнөөлт шавьжид нэрвэгдээгүй, нахиа нь задраагүй, уян зөөлөн саглагар мөчиртэй, иш нь бүдүүвтэр, эгц шулуун, бат бөх үндэс ихтэй, өсөлт сайтай байна.		

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ОЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН




Б.ХАСЫМ

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ОЙН ИНЖЕНЕР

М.НУРСУЛТАН



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 9/16

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны төсөвт тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 15000 /арван таван мянга/ ширхэг тарьц, суулгац нийлүүлэх тендерт шалгарсан Балгын ХХК-д 68684001 /жаран найман сая зургаан зуун наян дөрвөн мянга нэг/ төгрөгийг гэрээний дагуу шийлжүүлэхийг нягтлан бодогч /Х.Тилеухан/-д зөвшөөрсүгэй.

2. Дээрхи арга хэмжээний ажлыг зохион байгуулах, гэрээ хийж гүйцэтгэлд хяналт тавьж дүгнүүлж ажиллахыг ажлын хэсэг /Б.Хасым/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.МАРАТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

БАЯН-ӨЛНИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ш. МАРАТ

ГҮЙЦЭТГЭГЧ:

"БАЛГЫН" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ Х. МЫРЗАБЕК



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд
Тарьц, суулгац нийлүүлэх тухай гэрээ

2022 оны 05 сарын 24-ны өдөр

№ БОХ-06/2022

Өлгий хот

Нэг талаас Баян-Өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (цаашид "захиалагч" гэх)-ын дарга Ш. Марат, нөгөө талаас Балгын ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх)-ын захирал Х. Мырзабек нар дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Иргэний тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ойжуулалт, ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд "Тэрбум мод" аяны хүрээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд тарьц, суулгац нийлүүлэх хийгдэхтэй холбогдуулан захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино

Хоёр. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Гүйцэтгэгчээс гэрээт ажлын дагуу доорх хүснэгт байга модны суулгацыг стандартын дагуу хүлээж авах үүрэгтэй.

№	Суулгацын нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо
1	Бургас	ширхэг	5000
2	Улиас	ширхэг	3000
3	Хайлаас	ширхэг	2500
4	Шар хуайс	ширхэг	1500
5	Шилмүүст мод	ширхэг	1000
6	Гоёлын мод	ширхэг	1000
7	Жимс жимсгэний мод	ширхэг	1000
Дүн		ширхэг	15000

2.2 Гүйцэтгэгчийн ажлын явцад үүссэн саад бэрхшээлийн улмаас гэрээт ажил хийгдээгүй буюу дутуу хийгдсэн тохиолдолд олгосон санхүүжилтийг буцаан нэхэмжлэх эрхтэй.

2.3 Ажил гүйцэтгэж байх хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын газраас төслийн менежер томилон ажлын гүйцэтгэлд хяналт тавина.

2.4 Ажлын нийт санхүүжилт 68.684.001.0 / жаран найман сая зурган зуун наян дөрвөн мянган нэг / төгрөг бөгөөд захиалагч нь дараах хуваарийн дагуу санхүүжилтийг олгоно.

Эхний санхүүжилт	70%	48.078.801
Сүүлийн санхүүжилт	30%	20.605.200

2.5 Гэрээнд тусгасан ажлын хэрэгжилтийн явцад тус газраас томилогдсон ажлын хэсэг хяналт тавьж гүйцэтгэлийн хэмжээ, үр дүнг тодорхойлон дүгнэлт гаргана. Гүйцэтгэлийн хэмжээ, үр дүнгээр нь санхүүжилтийг 6 сард багтаан хийнэ.

Гурав. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 "Тэрбум мод" аяны хүрээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд нийлүүлэх тарьц, суулгацыг стандарт чанарын шардлага хангасан суулгац байх.

3.2 Ажлын гүйцэтгэлийн эцсийн мэдээ, баримт материалыг 06 сарын 15-ны дотор захиалагчид хүргүүлэх үүрэгтэй.

3.3 Гүйцэтгэгч ажлын чанарт сөргөөр нөлөөлөх эсхүл хугацаа хоцроож болзошгүй нөхцөл байдлын талаар Байгаль орчин, аялал жуулчлалын газарт аль болох урьдаас урьдчилан анхааруулах үүрэгтэй.

3.4 Гүйцэтгэгч нь захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

3.5 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дөрөв. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

4.1. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.


4.2. Гэрээний аль нэг тал үүргээ зөрчсөн тохиолдолд Иргэний хуулийн 225, 226 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл, журмын дагуу нөгөө тал гэрээг цуцалж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

4.3. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих шатны Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Баян-Өлгий аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн



Б. ХАСЫМ

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум 5-р баг
 БОАЖГазар
 Утас: 99423066, 94509901
 Харилцагч банкны нэр: Төрийн сан
 Дансны дугаар: 100020013401
 Регистрийн дугаар: 9006974

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Балгын" ХХК-ний захирал



Х. МЫРЗАБЕК

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум 4-р баг
 ХХК
 Утас: 99425631
 Харилцагч банкны нэр: Голмт банк
 Дансны дугаар: 5805011518
 Регистрийн дугаар: 2142864

ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛГ № 91

2022 оны 6 сарын 29 өдөр


Байгууллагын нэр: Байгаль орчны газар	Дансны дугаар	10,000,000.00
Регистрийн дугаар: 9006974	100020013001	
Хүлээн авагчийн нэр: БАЛГЫН ХХК	Дансны дугаар	
Регистрийн дугаар: 2142864	5805011518	
Хүлээн авагчийн банк: Голомт банк	Ангилал	
Мөнгөн дүн үсгээр: Дрван сая төгрөг 00 мөнгө		
Үйлчлэний утга: Төрц, суулгац нийлүүлэх гэрээний эхний санхүүжилтийн үлдэгдэл	71406 - Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	10,000,000.00
	81701 - Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	
	0000 - Төрийн сан	
	210801-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	

Хяналтын хуудас №: 91

Үндэслэх бичиг баримтын нэр	Он сар, дугаар	Төрийн сангийн тэмдэглэгээ
Гэрээ	2022.05.24 №БОХ-06/2022	✓
Тушаал	2022.05.24 №А/16	✓

Тамга

Дарга:  /Ш.Марат/
Нягтлан босгогч:  /Х. Тилеухан/








ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022. 10. 10

Өлгий сум

Хуралыг Баян-Өлгий Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хурлын өрөөнд 10⁰⁰- цагт хийв.

Хуралд:			
Комиссын дарга:	БОАЖГазрын мэргэжилтэн:		Б. ШӨГЕН
Гишүүд:	БОАЖГазрын нярав:		Ө. ДАУРЕНБЕК
	СДОАнгийн ажилтан:		С. ГҮЛБАНУ /тохиролцсоноор/
	Өлгий сумын Хот тохижуулах албаны экологийн ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн		А. АЙБЕК /тохиролцсоноор/
Нарийн бичгийн дарга:	СДОАнгийн мэргэжилтэн:		М. НУРСУЛТАН нар оролцов.

Хурлаар хэлэлцсэн асуудал: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд 15 мянган ширхэг тарьц суулгац худалдан авах тендерт шалгарсан “Балгын” ХХКомпаны намрын улиралд нийлүүлэх 7000 мянган ширхэг тарьц суулгацыг хүлээн авах талаар.

Б. Шөген: “Балгын” ХХКомпаны намрын бүх нийтээр мод тарих өдөр өгөх 7000 мянган ширхэг суулгацыг хүлээж авна. Хаврын улиралд 8000 мянган ширхэг суулгацыг хүлээлгэж өгсөн байсан. Гэрээний дагуу үлдсэн суулгацуудыг хүлээж авах болно.

М. Нурсултан: “Балгын” ХХКомпаны нийлүүлэх ёстой 7000 ширхэг суулгацыг энэ долоо хоногт батгаан хүлээж авах хэрэгтэй. Бүх нийтээр мод тарих өдрөөр албан байгууллагуудад хувиарлаж өгнө. Тоо ширхэгийг сайн тоолж авахгүй бол хүлээж авсны дараа манай байгууллага тоолж бүртгэлжүүлж албан байгууллагуудад хувиарлаж өгөхдөө дутуу бол хариуцлагын асуудал болно.

А. Айбек: Санал нэгтэй байна. Моднуудын өндөр, үндэсний хөгжлийг сайн харах хэрэгтэй. Тооллогоо бүрэн хийж хүлээж авсан нь дээр. Бүгдээрээ газар дээр нь очиж тоолж хүлээн авч Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд хүлээлгэж өгье.

Ө. Дауренбек: Санал нэгтэй байна. Тоолж үзэж авсан нь дээр.

С. Гүлбану: “Балгын” ХХКомпаны 7000 ширхэг суулгацыг хурдан авах хэрэгтэй. Энэ моднуудад хувиарлалт хийх хугацаа бас хэрэгтэй үлдсэн моднуудыг манай мод үржүүлгийн талбайгаас бэлтгэх шаардлага гарах учраас эртхэн үзэж тоолж авах нь зүйтэй.

Б. Шөген: Та бүхний хэлсэн саналаар маргааш “Балгын” ХХКомпаны 7000 ширхэг суулгацыг хүлээн авч Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд хүлээлгэж өгье.

Шийдвэрлэсэн нь: “Балгын” ХХКомпаны 7000 ширхэг суулгацыг гэрээний дагуу хүлээн авч Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд хүлээлгэж өгөхөөр шийдвэрлэв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



М. НУРСУЛТАН

“БАЛГЫН” ХХК-НЫ ТЕНДЕРЭЭР НИЙЛҮҮЛСЭН СУУЛГАЦЫГ ХҮЛЭЭН АВСАН АКТ

2022.10.17

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд 15 мянган ширхэг тарьц суулгац худалдан авах тендерт шалгарсан “Балгын” ХХКомпаны намрын улиаралд нийлүүлсэн 7000 мянган ширхэг тарьц суулгацыг хүлээн авсан.

№	Модны төрөл	Тоо ширхэг
1	Улиас	1970
2	Бургас	4140
3	Гоёлын мод	875
4	Шилмүүст мод	40
	Нийт	7025

АКТ ТОГТООСОН:

КОМИССИЙН ДАРГА: БОАЖГазрын мэргэжилтэн:

Б. Шөген

ГЭЖЛҮҮД:

СДОАнгийн ажилтан

С. Гүлбану
/тохиролцсоноор/

БОАЖГ-ын нярав

Ө. Дауренбек

Өлгий сумын хот тохижуулах албаны
экологийн ногоон байгууламж
хариуцсан мэргэжилтэн

А. Айбек
/тохиролцсоноор/

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА:

СДОАнгийн мэргэжилтэн

М. Нурсултан
/тохиролцсоноор/

ЗЭВШЭӨРСӨН:

“Балгын” ХХКомпани захирал

Х. Мырзабек



“БАЛГЫН” ХХК-НЫ ТЕНДЕРЭЭР НИЙЛҮҮЛСЭН СУУЛГАЦЫГ ХҮЛЭЭН АВСАН АКТ

2022.05.31

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд 15 мянган ширхэг тарьц суулгац худалдан авах тендерт шалгарсан “Балгын” ХХКомпани хаврын улиаралд нийлүүлсэн 8000 мянган ширхэг тарьц суулгацыг хүлээн авсан.

№	Модны төрөл	Тоо ширхэг
1	Улиас	1030
2	Бургас	1110
3	Гоёлын мод	135
4	Шилмүүст мод	140
5	Хайлаас	3010
6	Шар хуайс	1475
7	Жимсний мод	1100
	Нийт	8000

АКТ ТОГТООСОН:

КОМИССИЙН ДАРГА: БОАЖГазрын мэргэжилтэн:



Б. Хасым


ГИШҮҮД:

Өлгий сумын хот тохижуулах албаны
экологийн ногоон байгууламж
хариуцсан мэргэжилтэн



А. Айбек
/тохиролцсоноор/

БОАЖГ-ын нярав



Ө. Дауренбек

Өлгий сумын дэд бүтэц хариуцсан
мэргэжилтэн



А. Айтуган
/тохиролцсоноор/

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА:

СДОАнгийн дарга



Х. Есенбол
/тохиролцсоноор/

ЗЭВШӨӨРСӨН:

Балгын” ХХКомпани захирал



Х. Мырзабек

“Балгын” ХХК-ны Тарьц, суулгац нийлүүлэх БӨАОНӨГ/202205091 урилгын
дугаартай ажлын товч тайлан

2022.10.20

Өлгий хот

“Балгын” ХХК нь Баян-Өлгий аймгийн Засаг Даргын БӨАОНӨГ/202205091 урилгын дугаартай “Тарьц, суулгац нийлүүлэх” тендер шалгаруулалтад 68 684 001 төгрөгөөр нийт 15000ш тарьц, суулгацыг Б/23 тоот тушаалын дагуу хавар 8000ш, намар 7000ш нийлүүлэхээр гэрээний дагуу хүлээлгэн өгөх ажлыг цаг хугацаандаа зохион байгуулж ажиллав.

Энэхүү ажлын хүрээнд тус аймгийн БОАЖГ-ын даргын 2022 оны 05-р сарын 30-ны өдрийн Б/23 тоот тушаалын дагуу байгуулагдсан БОАЖГ-ын ойн мэргэжилтэн Б.Хасым даргатай 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж хавар 5-р сарын 31-ны өдөр 8000ш улиас (1030ш), бургас (1110ш), хайлаас (3010ш), шар хуайс (1475ш), шинэс (140ш), гоёлын мод (135ш), жимсний мод (1100ш) хүлээн авсан бол, намар 10-р сарын 10,17-ны өдрүүдэд БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Шөген даргатай 5 хүний бүрэлдэхүүнтэй комисст нийт 7000ш улиас (1970ш), бургас (4140ш), гоёлын мод (875ш), шилмүүст мод (40ш) зэрэг модны суулгацуудыг мэргэжлийн дагуу хүлээлгэн өгч хавар, намрын мод тарих өдрүүдэд нийлүүлсэн болно.

Энэхүү ажлын хүрээнд ямар нэг нь маргаан, дутагдал гараагүй зохих журмын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

“Балгын” ХХК нь модны суулгацыг мэргэжлийн дагуу стандарт шаардлагын хүрээнд бэлтгэж тоолж хүлээлгэн өгч ажиллав. Мод суулгацыг хүлээн авч байгаа үед бэлтгэсэн фото зураг, хүлээлгийн акт зэрэг холбогдолтой материалуудыг хавсаргав.

Товч тайлан бичсэн “Балгын” ХХК-ны зөвлөх


Доктор (Ph.D) Х.Мырзабек

Хавар, намар модны суулгац хүлээн авч байгаа байдал





Бургас, улиас





Чацаргана, шилмүүст мод

**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ТАРЬЦ, СУУЛГАЦ
НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ**

Дугаар № БОАЖГ-/БӨАОНӨГ/202205091

Нийлүүлэгч	Баян-Өлгий аймаг, Өлгий сум 11-р баг “БАЛГЫН”ХХК
Гэрээний дүн	68 684 001,0 төгрөг
Санхүүжүүлэх эх үүсвэр	БОХ-06/2022
Ажлын нэр ба байршил	Баян-Өлгий аймаг, Өлгий сум 11-р баг
Төслийн менежер	Х.Мырзабек

НЭГ. ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

НӨХЦӨЛ	ХЭРЭГЖИЛТ
<p>1.1 Монгол улсын иргэний тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ойжуулалт, ойг нөхөн сэргээх байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны ТЭРБУМ МОД аяны хүрээнд Баян-Өлгий аймгийн хэмжээнд ТАРЬЦ, СУУЛГАЦ нийлүүлэх ажлыг захиалагч, гүйцэтгэгчийн хоронд үүсэх харилцааг зохицуулах харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.</p> <p>Захиалагч нь тарьц, суулгац нийлүүлэх, ажил нийлүүлэх № БОАЖГ-/БӨАОНӨГ/202205091 дугаартай ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хорооны дүгнэлтээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 заалтын дагуу тарьц, суулгац худалдан авахад санхүүжүүлнэ</p>	<p>Нийлүүлэгч уг барааг захиалагчдад гэрээний дагуу хүлээлгэн өгч, төлбөрийг гүйцэтгэлээр тооцож гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн.</p>
<p>1.2 Худалдагч худалдан авагч байгууллагаас тавих чанарын шаардлагыг бүрэн хангасан байна.</p>	<p>Худалдагч худалдан авагч байгууллагаас тавих чанарын шаардлагыг бүрэн хангаж ажилласан.</p>
<p>1.3 Энэхүү гэрээнд заасан үйл ажиллагааг явуулахад МУ-ын Иргэний хуулийг удирдлага болгоно.</p>	<p>Энэхүү гэрээнд заасан үйл ажиллагааг явуулахад МУ-ын Иргэний хуулийг удирдлага болгосон.</p>
<p>1.4 Тэрбум мод аяны хүрээнд ойжуулалт, ойн нөхөн сэргээх байгалийн сэргэн ургуулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 15000 ширхэг модны суулгац нийлүүлнэ.</p>	<p>Тэрбум мод аяны хүрээнд ойжуулалт, ойн нөхөн сэргээх байгалийн сэргэн ургуулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 15000 ширхэг модны суулгацыг нийлүүлсэн.</p>

ХОЁР. ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

НӨХЦӨЛ	ХЭРЭГЖИЛТ
2.1 Гүйцэтгэгч байгууллагаас тарьц, суулгацыг стандартын дагуу хүлээж авах үүрэгтэй.	15000 ширхэг тарьц, суулгацыг стандартын дагуу хавар 05-р сарын 31-д 8000 ширхэг, намар 10-р сарын 17-д 7025 ширхэг тус тус ажлын хэсэгт хүлээлгэн өгч акт үйлдсэн.
2.2 Гүйцэтгэгч гэрээний дагуу гэрээт ажлыг гүйцэтгэхгүй буюу дутуу хийгдсэн тохиолдолд хангасан санхүүжилтыг буцаан нэхэмжлэх үүрэгтэй.	Гэрээний дагуу гэрээт ажлыг хугацаандаа бүрэн гүйцэтгэсэн.
2.3 Ажил гүйцэтгэж байх хугацаанд БОАЖГ-аас төслийн менежер томилон ажлын гүйцэтгэлд хяналт тавина.	БОАЖГ-аас томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хоёр удаа хяналт тавьж ажилласан.
2.4 Ажлын нийт санхүүжилт 68 684 001 төгрөг бөгөөд захиалагч нь дараах хуваарийн дагуу санхүүжилт олгоно. Эхний санхүүжилт 70% 48 078 801 төгрөг, сүүлийн санхүүжилт 30% 20 605 200 төгрөг.	Захиалагч байгуулга гэрээнд заасны дагуу эхний санхүүжилтийн 70% болох 48 078 801 төгрөгийг шилжүүлсэн. Мөн сүүлийн санхүүжилт 30% 20 605 200 төгрөгийг гэрээ дүгнэж олгохоор болсон. .
2.5 Гэрээнд тусгасан ажлын хэрэгжилтийн өмнөд тус газраас томилогдсон ажлын хэсэг хяналт тавьж гүйцэтгэлийн хэмжээ үр дүнг тодорхойлон дүгнэлт гаргана. Гүйцэтгэлийн хэмжээ үр дүнгээр нь санхүүжилтийг 6 сард буцаан хийнэ.	Захиалагч байгуулга ажлын хэсэг байгуулж гэрээнд заасаны дагуу хяналт тавьж үр дүнг тооцож, гэрээ дүгнэж сүүлийн санхүүжилт болох 30% 20 605 200 төгрөгийг олгохоор болсон.

ГУРАВ. ХУДАЛДАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

НӨХЦӨЛ	ХЭРЭГЖИЛТ
3.1 Нийлүүлэх тарьц, суулгац стандарт шаардлага хангасан байх.	Нийлүүлэх тарьц, суулгац стандарт шаардлага хангасан.
3.2 Ажлын гүйцэтгэлийн эцсийн мэдээ материалыг 6 сарын 15-ний дотор захиалагчид өргүүлэх үүрэгтэй.	Ажлын гүйцэтгэлийн эцсийн мэдээ тайланг хугацаанд хүргүүлсэн.
3.3 Гүйцэтгэгч ажлын чанарт сөргөөр нөлөөлөх эсхүл хугацаа хоцроож болзошгүй өмнөд байдлын талаар БОАЖГ-т урьдчилан мэдэгдүүлэх үүрэгтэй.	Нөхцөл байдал үүсээгүй.
3.4 Гүйцэтгэгч нь захиалагч гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хариуцлагыг биелүүлсэн.	Гүйцэтгэгч болон захиалагч нар хооронд байгуулсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хариуцлагыг биелүүлсэн.
3.5 Гүйцэтгэгч гэрээний дагуу захиалагчийн төлбөр төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх өмнөд нийцүүлэн заасан ажлыг гүйцэтгэж, зардал гологдол арилгаг үүрэг хариуцлагыг биелүүлсэн.	Нөхцөл байдал үүсээгүй.

ДӨРӨВ.МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

НӨХЦӨЛ	ХЭРЭГЖИЛТ
4.1. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичиг болон утсан холбоогоор харилцана.	Албан бичиг болон утсаар харилцсан.
4.2. Гэрээний аль нэг тал үүргээ зөрчсөн тохиолдолд иргэний хуулийн 225, 226 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл, журмын дагуу гэрээг цуцалж учирсан хохирлоо нөхөн төлүүлэх шаардах эрхтэй.	Нөхцөл байдал үүсээгүй.
4.3. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол захиргааны хэргийн шүүхэд эргэмжлэл гаргана.	Нөхцөл байдал үүсээгүй.

ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БОАЖГ-ын мэргэжилтэн

Б. ХАСЫМ



(Гарын үсэг)

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум

5-р баг БОАЖГ

Утас: 94509901

Харилцагч банкны нэр: Төрийн сан

Дансны дугаар: 100020013401

Регистрийн дугаар: 9006974

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“БАЛГЫН” ХХК

ЗАХИРАЛ А.ЕРКЕГҮЛ



(Гарын үсэг)

Хаяг: Баян-Өлгий аймаг Өлгий сум

11-р баг “БАЛГЫН” ХХК

Утас: 99423066

Харилцагч банкны нэр: Голомт банк

Дансны дугаар: 5805011518

Регистрийн дугаар: 2142864

АЙМГИЙН КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.12.06

Хурлын 2022 оны 12-р сарын 06-ны өдрийн 10 цаг 00 минутанд ЗДТГазрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Анарын өрөөнд хуралдав.

Хурлыг: ХОХБТХэлтсийн дарга Х.Анар удирдаж явуулав.

Хуралд: Комиссын дарга ХОХБТХэлтэсийн дарга Х.Анар

Нарийн бичгийн дарга БОАЖГазрын ахлах мэргэжилтэн С.Мандат

Гишүүд: - МХГ-ын байгаль орчны хяналтын улсын байцаагч Т.Бауыржан,

- Төрийн сангийн мэргэжилтэн Б.Маргулан ,
- Сум дундын ойн ангийн мэргэжилтэн М.Нурсолтан
- Байгаль орчин ,аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Гүлжан
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналт,шалгалт хариуцсан мэргэжилтэн Н.Болатхан нар оролцов.

Хэлэлцэх асуудал: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймгийн Засаг дарга 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээнд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2 дугаар хавсралтанд тусгагдсан 16 төрлийн нэр бүхий ажлын талаар гишүүдийн санал, дүгнэлт гаргах.

Хийгдсэн ажлуудын талаар ажлын хэсгийн нарийн бичгийн дарга С.Мандат танилцуулав.

С.Мандат: №22-02 тоот гэрээний 2 дугаар хавсралтанд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх ажлууд. Үүнд:

1. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. 2.0 сая төгрөг
2. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх./ таван сумын байгаль хамгаалагчийг Мотоциклээр хангах/ 12.5 сая төгрөг
3. Байгаль орчны хамгаалах нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулах. 3.0 сая төгрөг
4. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Веб сайт, цахим мэдээллийг шинэчлэх 500 мянга
5. Аймгийн хэмжээний ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах. 40.0 сая төгрөг

6. Зэрлэг амьтдад зориулж, биотехникийн арга хэмжээ авах 8.0 сая төгрөг
7. Байгалийн нөөцийг хамгаалах ажлын хүрээнд Чигэртэйн голын ай савын БЦГ-ын тодорхой цэгүүдэд ан амьтны тооллогыг 2 удаа зохион байгуулж (төллөх үе, орооны үе) Биотехникийн арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах. 2.0 сая төгрөг
8. Булаг шандны эхийг хамгаалж, орчныг тохижуулах. 9.0 сая төгрөг
9. Монгол Алтай Нурууны Улсын Тусгай Хамгаалалттай газарт ойжуулалт хийх. 3.0 сая төгрөг
10. Гоёл чимэглэл , жимсний модны суулгацаар хангах. 15.0 сая төгрөг
11. Алтай Таван Богдын БЦГ-ын төлөвлөсөн маршрутын дагуу отоглох цэг байгуулах 12.0 сая төгрөг
12. “ Ай-Ти – Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын компаниуд болон иргэдийг оролцуулах . 3.0 сая төгрөг
13. Байгаль, Түүх , соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, цар хүрээг өргөжүүлэх /Бугат суманд бүргэдийн баяр зохион байгуулах/. 10.0 сая төгрөг
14. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд СДОАнгийн мод үржүүлгийн газрыг Трактор, усны цахилгаан насос, бороожуулагчаар хангах 57.5 сая төгрөг

Эдгэр 14 хэрэгжүүлэх ажлын нэгдүгээрт Алтай Таван Богдын БЦГ-ын төлөвлөсөн маршрутын дагуу отоглох цэг байгуулах 12.0 сая төгрөгийн ажлын зарим ажилууд дутуу хийгдсэн тул гэрээгээ сунгуулан 2023 оны 5-р сард багтаан хийхээр болсон. Хоёрдугаарт: СДОАнгийн мод үржүүлгийн талбайн ажлыг дэмжиж трактор, усны цахилгаан насос, бороожуулагчаар хангах 58,5 сая төгрөгийн тендрийн ажилд “ПЖГМ” ХХК шалгарч бараа нийлүүлэх ажлыг хил, гаалийн түр саатал гарсан тул 2023 оны эхний улиралд нийлүүлэхээр гэрээгээ сунгуулсан болно. Гуравдугаарт: 9. Монгол Алтай Нурууны Улсын Тусгай Хамгаалалттай газарт ойжуулалт хийх. 3.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй болно.

Н.Болатхан: Дээрх дутуу хийгдсэн ажлуудын гэрээнд тусгагдсан санхүүжилтийг хүлээж авсны дараа олгох нь зүйтэй байх

М.Нурсултан: Болатханы саналыг дэмжиж байна.

Б.Гүлжан, Т.Бауыржан: Бусад хийгдсэн ажлуудын санхүүжилтийн олгох нь зүйтэй байна.

Шийдвэрлэсэн нь:

1. БОАЖСайд аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны №22-02 дугаар гэрээнд тусгагдсан орон нутгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн дээрх 3 ажилаас бусад ажлуудын дутуу санхүүжилт болох булаг шандны эхийг хамгаалах 1770,000 төгрөг, “Балгын” ХХК-ны тарьц, суулгац нийлүүлэх 20.605.200 төгрөг, Байгалийн нөөцийг хамгаалах ажлын хүрээнд Чигэртэйн голын ай савын БЦГ-ын тодорхой цэгүүдэд зэрлэг ан амьтдад био техникийн арга хэмжээ авах 600.0 төгрөгийн санхүүжилт болон бусад хийгдсэн ажлуудын санхүүжилтийг 100% олгох нь зүйтэй.

2. Бүргэдийн баяр зохион байгуулах 10,000,000төгрөгийг 2023 онд шилжүүлж ,
“ПЖГМ” ХХК-ны СДОАнгийн мод үржүүлгийн талбайн ажлыг дэмжиж трактор, усны цахилгаан насос, бороожуулагчаар хангах 58,5 сая төгрөгийн 28,750,000төгрөгийн ажил, “Ронго трейвл” компаны Алтай Таван Богдын БЦГ-ын төлөвлөсөн маршрутын дагуу отоглох цэг байгуулах 12.0 сая төгрөгийн 7.000.000төгрөгийн ажлын гэрээг сунгаж, 2023 оны эхний улиралд багтаан гэрээний дагуу хүлээж авахыг БОАЖГазарт даалгах нь зүйтэй.

Комиссын дарга:ХОХБТХэлтийн дарга

Гишүүд :МХГ-ын БОХУБайцаагч


БОАЖ Газрын мэргэжилтэн

БОАЖГазрын мэргэжилтэн

ТСХэлтсийн мэргэжилтэн

СДОАнгийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн



Х.Анар

Т.Бауыржан

Б.Гүлжан

Н.Болатхан

Б.Маргулан

М.Нурсултан

С.Мандат

A large, stylized handwritten signature in black ink, written over the text of the Secretary's name.